Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 тоот тушаалын
7 дугаар хавсралт

Тэгш хамран сургах боловсролын хэлтэс

2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| № | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэл-ийн хувь | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | | Өөрийн үнэлгээ | ХШҮ |
| Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ | | | | | | | | | |
| 1.1. | Боловсролд бүх хүүхэд, залуучуудыг тэгш хамруулах зарчмыг баримталж, ялгаатай хэрэгцээтэй хүүхэд, залуучуудыг хамруулсан, тэдний гэр бүл, орон нутгийн онцлог байдалд нийцсэн, тохируулгат орчин, дэд бүтэцтэй, хувилбартай, гэрийн | - | - | - | - | | - | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | сургалттай боловсролын үйлчилгээг бүх түвшинд бий болгоно | | | | | | | | |
| 1.1.1 | Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг гэр бүл, орон нутгийн онцлог байдалд нийцүүлэн, хувилбарт сургалтад хамруулах ажлыг удирдлага, зохицуулалтаар хангах | 4,617.10, 12,699.80, 11,823.10, 23,320.30, 2,366.00 | Ялгаатай хэрэгцээтэй 2-5 насны нийт хүүхдээс сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдийн эзлэх хувь, Ялгаатай хэрэгцээтэй 6-15 насны нийт хүүхдээс ерөнхий боловсролын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдийн эзлэх хувь | 57.4 (Хөгжлийн бэрхшээлтэй), 54.6 (Малчдын), 6.5 (Сургууль завсардалт), 76.2 (Хөгжлийн бэрхшээлтэй), 54.6 (Танхимын сургалтад тогтмол хамрагдах боломжгүй) | 57.4, 54.6, 6.5, 76.2, 54.6 | 69.6, 56.1, 5.7, 77.7, 65 | Ялгаатай хэрэгцээтэй суралцагчдыг боловсролд тэгш хамруулах асуудлаар дараах арга хэмжээг авч, хэрэгжүүлж, хамрагдалт нэмэгдсэн байна. 1. ЗГ-ын 2024 оны 48 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд Боловсролын сайдын 2024 оны А/145, 2025 оны А/76 дугаар тушаалыг тус тус батлуулж, НЕБ-ын 112-р сургуулийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг шинэчилж, тусгай зөвшөөрлийг еб, боловсрол нөхөн олгох хөтөлбөр, цахим сургалт зохион байгуулах чиг үүрэгтэй болгон өөрчилж, монгол улсад дацан | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хийдэд шавилан сууж буй хүүхдүүд болон БНЭУ-д дацан хийдэд шавилан сууж буй 433 ламаас 302-ыг боловсрол нөхөн олгох сургалтад хамруулж, лам хүүхдүүдийг боловсролд бүрэн хамруулла. 2. ШШГЕГ-ын харьяа Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад хүмүүжиж, НЕБ-ын 110-р сургуульд суралцаж буй хүүхдүүдийн сурах эрхийг хангаж, 10 багц 860 ш сурах бичиг, 5 нөүтбүүк, 15 хроум бүүкээр хангаж, хүмүүжиж буй 41 суралцагчийг Мэдлэ цахим сургуульд хамруулж, эрх нь хязгаарлагдсан хүүхдүүдийг боловсролын үйлчилгээнд бүрэн хамруулав. Сургалтын хэрэглэгдэхүүнээр бүрэн хангаж, Мэдлэ цахим | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сургуульд хамруулсны үр дүнд хоригдож буй хүүхдүүдээс 1 нь улсын түүхийн олимпиадаас хүрэл медаль, 1 нь химийн олимпиадаас мөн хүрэл медаль хүртсэн. 3. Асрамж халамжийн төвд амьдарч буй хүүхдүүдийн сурах эрхийг хангах талаар халамжийн төвийн удирдлагууд, багш, нийгмийн ажилтнуудад арга зүйн сургалт зохион байгуулж, сургууль завсардсан хөгжлийн бэрхшээлтэй 8 суралцагчийг дэмжих үйлчилгээнд хамруулах ажлыг арга зүй, зохицуулалтаар хангав. 4. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг боловсролд тэгш хамруулах хүрээнд дэмжих үйлчилгээг туршин | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хэрэгжүүлж, 111 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг болвсролд нэмж хамруулав. Үүний үр дүнд хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн боловсролд хамрагдалт 80 хувьд хүрсэн ба хавсарсан хөгжлийн бэрхшээлтэй 2007 хүүхэд боловсролын гадна байгааг дэмжих үйлчилгээгээр боловсролд хамуулахаар төлөвлөж байна. СӨБ-д 2150, ЕБС-д 6273 хөгжлийн бэрхшээлтэй суралцагч хамрагдсан.<br>Хавсралт: 8 файл | | |
| 1.1.2 | Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын байгууллагад ялгаатай хэрэгцээтэй суралцагчид | 3,000.00, 3,000.00 | Суралцагчийн ялгаатай хэрэгцээнд тохирсон, сургалтын орчин бүрдсэн цэцэрлэгийн тоо , Суралцагчийн | 180, 230 2150 6273 | 10, 10 | 50, 50 | ЗГ-ын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт жил бүр 50 сургууль, 50 цэцэрлэгт ялгаатай хэрэгцээтэй суралцагчид зориулсан | 100% | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | тэгш хамрагдахад шаардлагатай, орчинг үе шаттай нэмэгдүүлж, боловсролын үйлчилгээний хүртээмжийг сайжруулах ажлыг удирдлага зохицуулалтаар хангах | | ялгаатай хэрэгцээнд тохирсон, сургалтын орчин бүрдсэн сургуулийн тоо, СӨБ, ЕБС-д хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тоо | | | | сургалтын орчин бүрдүүлэх талаар туссан ба Боловсролын сайдын 2025 оны "худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлах тухай" А/21 дүгээр тушаалд хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлогт тохирсон тохирох хэрэглэгдэхүүн худалдан авахад 773,0 сая төгрөгийг батлуулсан. Энэхүү төсвөөр еб-ын 20 сургуулийн дэмжих танхимд шаардлагатай тоног төхөөрөмж, нийслэлийн ерөнхий боловсролын 25,55,63,70-р сургуульд ширээ, сандал нийлүүлэхээр техникийн тодорхойлолтыг батлуулж, тендр зарлагдсан ба нийлүүлэгч компанид зарим нэмэлт тодруулга өгч хамтарч ажиллаж байна. | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Түүнчлэн Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төслийн санхүүжилтээр төслийн зорилтот 18 сургуулийн дэмжих танхимд 193,0 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэхээр холбогдох журмын дагуу ажиллаж байна.<br>Хавсралт: 4 файл | | |
| 1.1.3 | Бага боловсрол эзэмшиж буй үндэсний цөөнх хүүхдүүдийг казак, тува хэлний сурах бичгээр бүрэн хангаж, боловсролд тэгш хамруулах ажлыг удирдлага зохицуулалтаар хангах | 60.00, 200.00 | Казах, тува хэл дээр бага ангийн сурах бичиг, хэрэглэгдэхүүнээр хангагдсан суралцагчийн эзлэх хувь, Сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангагдсан ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн хувь | 57.9, 24.5 | 57.9, 24.5 | 62.4, 35.2 | Боловсролын сайд, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар Сургуулийн өмнөх болон бага боловсролын хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд бага боловсролын казак, тува хэлний сургалтын хөтөлбөрийг боловсруулж, гарын авлага, дасгал ажлын дэвтрийг зорилтот сургуулиудад туршиж, | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хөтөлбөрийг сайжруулах ажилд дэмжлэг үзүүлж, арга зүйгээр хангаж хамтарч ажиллаж байна. Энэхүү хөтөлбөрийн шинэчлэлтэй уялдуулан бага боловсролын казак, тува хэлний сурах бичгийг шинэчлэн боловсруулж байгаа ба Боловсролын сайдын 2025 оны А/220 дугаар тушаалаар батлагдсан төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний санхүүжилтийн хуваарилалтын 2.1.12-т казаз, тува хэлний бага ангийн сурах бичиг хэрэглэгдэхүүнээр хангах зардалд 120,0 сая төгрөг тусган батлуулсан. Түүнчлэн Боловсролын сайдын 2025 оны “Чиглэл батлах тухай” А/229 дүгээр тушаалаар “Хос | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хэлний боловсрол, сургалт зохион байгуулахад баримтлах чиглэл” -ийг батлуулж, тус чиглэлд казак, тува хүүхэд эх хэлээрээ уншиж судлах эх материалаар хангах талаар тусгасан ба УИХ-ын гишүүн С.Зулпхарын санаачилгаар д Бүгд Найрамдах Казакстан улсаас казак хэл дээрх 5000 гаруй уран зохиол, танин мэдэхүйн номыг татан авчрахаар холбогдох санхүүжилтийг шийдвэрлээд байна. Мөн дээрх Хос хэлний боловсрол, сургалт зохион байгуулах баримтлах чиглэлд Хөвсгөл аймгийн Цагаан нуур сумын цаатан иргэдэд зориулсан Тува хэл соёлын сургалтын жишиг хөтөлбөрийн гарын авлага боловсруулах ажлын зардлыг шийдвэрлэж, гарын | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | авлагыг боловсруулж эхлээд байна. Хавсралт: 13 файл | | |
| 1.1.4 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудыг мэргэжлийн болон техникийн боловсрол, дээд боловсролын сургалтын байгууллагад суралцах боломж, хүртээмжийг нэмэгдүүлэх ажлыг зохицуулалтаар хангах | 5,514.30, 2,616.20 | Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувь, Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувь | 0.7, 0.3 | 0.7, 0.3 | 1.5, 0.4 | Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг бүх түвшний сургалтын байгууллагад тэгш хамруулах бодлогын хүрээнд мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид зориулсан тусгай анги нээх, дадлагын баазын тоног төхөөрөмж, хэрэгдэгдэхүүнийг хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тусгай хэрэгцээнд нийцүүлж, аюулгүй ажиллагааг хангах чиглэлээр МБТБГ-тай хамтран ажиллаж байна. ГБХНХЯ-ны харъяа СЗСҮТ-ийн дэргэдэх МСҮТ-д хөгжлийн бэрхшээлтэй | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | иргэнд зориулсан шинэ хөтөлбөр нээхээр ажиллаж байгаа ба үүний үр дүнд хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид суурь боловсрол эзэмшсэний дараа мэргэжлийн боловсрол эзэмших боломж нь нэмэгдэх юм. Мөн НЕБ-ын 55-р сургуульд 4 мэргэжлээр мэргэжлийн сугалт зохион байгуулж, чадамжийн гэрчилгээ олгож эхлээд байна. Дээд боловсролын сургалтын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг тэгш хамруулахад анхаарч, стандартын шаардлага хангасан орц гарц, 00-ын асуудлыг 100 хувь шийдвэрлэх, цахим номын санг бий болгох талаар их дээд сургуулиудын УЗ-ийн дарга нарт | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | мэдээлэл өгч, ажилласан. Мөн Боловсролын сайдын 2025 оны А/220 дугаар тушаалаар батлагдсан боловсролын салбарт 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээний санхүүжилтийн хуваарь, жагсаалтад хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг боловсролд тэгш хамруулах асуудлаар 343,0 сая төгрөгийг тусган батлуулсан ба үүн дотор их дээд сургуульд суралцаж буй сонсголын бэрхшээлтэй суралцагчид тэмдэглэл хөтлөгч ажиллуулахад 50,0 төгрөгийг төсөвлөн батлуулж, хэрэгжүүлж байна. Түүнчлэн Тэгш оломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төслийн | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хүрээнд сонсголын бэрхшээлтэй суралцагчдад зориулсан туслах хэрэглэгдэхүүний тохируулга хийх ажлыг Боловсролын сайдын 2025 оны А/124 дугаар тушаалаар батлуулж, сайдын "Хуваарь батлах тухай" А/166 дугаар тушаалаар АШУҮХС-1, МУБИС-7, МУИС-5, ХААИС-1, ШУТИС-8, нийт 22 ш хроум бүүкийг их дээд сургуульд суралцаж буй сонсголын бэрхшээлтэй суралцагчийг боловсролд тэгш хамуулахад зориулан олгосон.<br>Хавсралт: 3 файл | | |
| 1.1.5 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэх аргачлалыг | - | - Сайдын тушаал | - Сайдын 2024 оны А/81 дүгээр тушаал | ГСТ-ний аргачлалыг боловсруулж батлуулсан байна. | ГСТ-ний аргачлалын хэрэгжилтийг удирдлага зохицуулалтаар хангаж ажиллсан байна. | Боловсролын сайдын 2025 оны А/196 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар "Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | боловсруулан батлуулж, хэрэгжилтийн удирдлага зохицуулалтыг хангах | | | | | | хамрагдах хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах аргачлал", 2 дугаар хавсралтаар "Ерөнхий боловсролын үйлчилгээнд хамрагдах хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах аргачлал"-ыг тус тус батлуулж, тус аргачлал болон сайдын А/81 дугаар тушаалаар батлагдсан СӨБ, ЕБС-д Ганцаарчилсан сургалтаар хичээллэх журмын хэрэгжилтийг арга зүйгээр ханган ажиллах талаарх чиглэлийг Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2/1986 тоот албан бичгээр БЕГ-т хүргүүлэв. Хавсралт: 2 файл | | |
| 1.1.6 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсрол эзэмшихэд дэмжих төвийн дүрмийг батлуулж, танхимын сургалтад тогтмол хамрагдах боломжгүй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол эзэмшүүлэхэд шаардлагатай салбар дундын зохицуулалтыг ханган ажиллах | -хувьсах зардал | -Боловсрол, эрүүл мэнд, гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан тушаал | -Дэмжих үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдийн тоо -78 | Боловсрол, эрүүл мэнд, гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан тушаал батлагдсан байна. | Танхимын сургалтад хамрагдах боломжгүй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн дэмжих үйлчилгээнд хамрагдалт 2 дахин нэмэгдсэн байна. | БЕХ-ийн 26.1.25-д заасан Хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсрол эзэмшихэд дэмжих үйлчилгээ үзүүлэх дүрмийн төслийг эцэслэн батлуулж, Боловсролын сайд, Эрүүл мэндийн сайд, Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2025 оны хамтарсан А/85, А/55, А/49 дүгээр тушаалаар батлуулж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 2025 оны 7169 дугаарт бүртгэгдсэн. “Хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсрол эзэмшихэд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий дэмжих төвийн дүрэм”-ийг хэрэгжүүлэх | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | асуудлаар 3 салбарын хамтарсан уулзалтыг 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр Боловсролын яаман дээр зохион байгууллаа. Уулзалтад Боловсролын яам, Эрүүл мэндийн яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны холбогдох нэгж, хэрэгжүүлэгч агентлагуудын албан хаагчид оролцож, салбар дундын уялдаа бүхий цогц дэмжлэгийг тэдэнд нэг дороос үзүүлэхэд тулгамдаж байгаа асуудлуудыг бодлогын түвшинд хэлэлцэж, шийдвэрлэх зорилгоор мэдээлэл солилцон дүрмийн хэрэгжилтийг хангах салбар хоорондын уялдаа бүхий тогтолцоог бүрдүүлэн үр | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | дүнтэй хэрэгжүүлэх чиглэлээр хэлэлцлээ. Мөн Хөгжлийн бэрхшээлтэй хүн бүрийн онцлог, үйлдлийн чадамжийг үнэлэх “Үйл ажиллагааны олон улсын ангилал (ICF) аргачлал”-ыг нэвтрүүлэх, хэрэгжүүлэх асуудлаар 3 салбарын хамтарсан уулзалтыг 2025.05.22-ны өдөр ГБХНХЯ-ны хурлын танхимд зохион байгууллаа. Уулзалтад Боловсролын яам, Эрүүл мэндийн яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны холбогдох нэгж, хэрэгжүүлэгч агентлагуудын албан хаагчид оролцож, салбар дундын уялдаа бүхий цогц дэмжлэгийг тэдэнд нэг дороос үзүүлэхэд | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тулгамдаж байгаа асуудлуудыг богино хугацаанд шийдвэрлэх зорилгоор салбар хоорондын уялдаа бүхий тогтолцоог бүрдүүлэхээр гаргасан замын зураглалын төслийг хэлэлцлээ. Хавсралт: 1 файл | | |
| 1.1.7 | Medle цахим сургуульд хэл засал, дохионы хэл, казак, тува хэлний цахим хичээл оруулах, цахим контент, хэрэглэгдэхүүнээр хангах ажлыг удирдлага, зохицуулалтаар хангах | - | -цахим ангийн тоо | Хэл засал, дохионы хэлний цахим контент , цахим хичээлүүд | Хүүхэд, багш, эцэг эхчүүдэд зориулсан хэл засал, дохионы хэлний цахим ангийг нээж, хичээллэж эхэлсэн байна. | Хүүхэд, багш, эцэг эхчүүдэд зориулсан хэл засал, дохионы хэлний цахим ангийг хичээллэж, казак, тува хэлний цахим ангийг нээх бэлтгэл ажлыг хангасан байна. | Мэдлэ цахим сургуульд хүүхэд, эцэг эх, багш нарт зориулсан хэл засал, дохионы хэлний цахим анги нээх ажлыг удирдлага зохион байгуулатаар хангаж, цахим сургалт зохион байгуулах багшийг 2 шатны сургалтанд хамруулж бэлтгэсэн. Түүнчлэн цахим сургалтад хамруулах суралцагч, эцэг эхийн бүртгэл хийх ажлыг мэдлэ цахим сургуультай хамтран зохион байгуулж, багш, | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | эцэг эх/асран хамгаалагч, хүүхдээс авах гурван төрлийн асуулгыг эцэслэн боловсруулж, Google Form ашиглан боловсруулан, аймаг, нийслэлийн Боловсролын газруудаар дамжуулан Боловсрол, шинжлэх ухааны яамны 2/2263 тоот албан бичгээр дамжуулан судалгаа авсан. Энэхүү цахим ангид элсэлт авахтай холбоотой постерийг бэлтгэн яамны болон БЕГ-ын цахим хуудаст байршуулсан. нийтдээ 128 хүүхэд, эцэг эх Мэдлэ цахим сургуульд хэл засал, дохионы хэлний ангид суралцахаар бүртгүүлээд байгаа бөгөөд цахим сургалтын хичээлийг эхлүүлээд байна. 2025-2026 оны | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хичээлийн жилд цахим сургалтыг эхлүүлэхээр бэлтгэл ажлыг бүрэн ханган ажиллаж байна. Түүнчлэн Боловсролын яам, Люксембургийн их хант улсын Гадаад Хэргийн Яамтай хамтран хэрэгжүүлж буй "ЕБС-ийн багш нарт тэгш хамран сургах боловсрол олгох онлайн платформ бий болгох нь" төслийн хүрээнд мэдлэ цахим сургуультай хамтран дохионы хэлний анхан, дунд шатны цахим сургалтын платформыг хөгжүүлсэн.<br>Хавсралт: 2 файл | | |
| 1.1.8 | Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа ялгаатай хэрэгцээтэй суралцагчид | - | Засгийн газрын гишүүдийн хамтарсан тушаалын төсөл, журмын төсөл | - | Журмын төслийг боловсруулна. | Журмын төслийг боловсруулж, хэлэлцүүлсэн байна. | СӨБЕБС-ийн тухай хуулийн 6.6-д заасан "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа ялгаатай хэрэгцээтэй | 100% | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх журмын төсөл боловсруулж, хэлэлцүүлэх | | | | | | суралцагчид хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх журам"-ын төсөл боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/59 дүгээр тушаалаар батлуулсан. Тус ажлын хэсэгт Боловсролын яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэндийн яамны болон харъяа байгууллагуудын холбогдох албан хаагчид, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн бус байгууллагын төлөөллийг оруулсан. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа ялгаатай хэрэгцээтэй | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | суралцагчид хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх журмын төслийг боловсруулж, ажлын хэсгээр хэлэлцүүлэхэд бэлтгэсэн.<br>Хавсралт: 2 файл | | |
| 1.1.9 | ЕБС, насан туршийн суралцахуйн төвийн суралцагчдад хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, хүний ялгаатай байдлыг хүндэтгэх, хүлээн зөвшөөрөх нөлөөллийн ажлыг удирдлага зохион байгуулалтаар хангах | - төсөл хөтөлбөрийн санхүүжилт | - нөлөөлийн үйл ажиллагааны тоо - хамрагдсан хүүхэд, эцэг эх, багш нарын тоо | - хөгжлийн бэрхшээлийн талаарх нөлөөллийн ажлын контент, цахим сургалт | ТББ-тай хамтран нөлөөллийн 50 ажил зохион байгуулсан байна. | - Нөлөөллийн ажилд 30,000 хүүхэд, эцэг эх хамрагдаж, хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт хандлага нэмэгдсэн байна. | Ерөнхий боловсролын болон насан туршийн суралцахуйн төвийн суралцагчдад хүний ялгаатай хэрэгцээг хүндэтгэх, хүлээн зөвшөөрөх үе тэнгийн найзуудаа дэмжих хамтрах чиглэлээр нөлөөлийн ажлыг 6 төрийн бус байгууллагатай хамтран бага, дунд, ахлах ангийн суралцагчид, эцэг эхчүүд, сургуулийн удирдлагууд, багш ажилтнуудад нийтдээ 66 удаагийн нөлөөллийн ажил зохион байгуулсан.Үүнд: | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 1. Боловсролын сайдын 2025 оны А/90 дүгээр тушаал, Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/36 дугаар тушаалын хүрээнд “Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих” төслийн санхүүжилтээр зорилтот 4 аймаг, нийслэлийн 2 дүүргийн 18 ерөнхий боловсролын сургуульд 2025 оны 4-5 дугаар сард “Хөгжлийн бэрхшээлтэй үе тэнгийн найзуудаа дэмжих чиглэлээр суралцагчдын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх” чиглэлээр 36 удаагийн нөлөөллийн арга хэмжээг амжилттай зохион байгууллаа. Тус арга хэмжээний хүрээнд “Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих” төслийн зорилтот ерөнхий | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | боловсролын сургуулийн бага, дунд, ахлах ангийн 26,103 суралцагчийн 20-иос доошгүй хувь, мөн хамран сургах тойргийн боловсролд хамрагдаагүй 6–16 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг хамруулах удирдамж боловсруулж батлуулсан.Сонгон шалгаруулалтаар 5 төрийн бус байгууллагыг нөлөөллийн ажлыг хэрэгжүүлэх гүйцэтгэгчээр сонгож, гэрээ байгуулан ажиллалаа.Гүйцэтгэгч байгууллагууд 2025 оны 4-5 дугаар сард зорилтот сургуулиуд дээр нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулж, сурагчдын дунд мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, эерэг хандлагыг төлөвшүүлэхэд | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | чиглэсэн сургалт, хэлэлцүүлэг, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн. 2. Боловсролын сайдын 2025 оны А/96 дугаар тушаалаар ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтан, сралцагчдын хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор нийслэлийн ерөнхий боловсролын 10 сургуульд 30 удаагийн нөлөөллийн ажлыг зохион байгуулж, 3000 суралцагч, 600 гаруй багш, албан хаагчдыг хамруулсан.<br>Хавсралт: 5 файл | | |
| 1.1.10 | ХШҮДАГ-тай хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд шаардлагатай, орчин, | - төсөл хөтөлбөрийн санхүүжилт | - Үнэлгээ хийсэн сургууль, цэцэрлэгийн тоо | - | - Ерөнхий боловсролын 18 сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд шаардлагатай, | - Ерөнхий боловсролын 50 сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд шаардлагатай, | Боловсролын сайдын 2025 оны А/182 дугаар тушаалаар батлагдсан "Ажлын хэсэг байгуулах, удирдамж батлах | 100% | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэглэгдэхүүний хүртээмж, хувьсах зардлын зарцуулалтад үнэлгээ хийж, СӨБ, ЕБС-ийн хувьсах зардалд хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн хувьсах зардлыг нэмэгдүүлэх талаар санал боловсруулах | | | | орчин, хэрэглэгдэхүүний хүртээмж, хувьсах зардлын зарцуулалтад үнэлгээ хийж, дүгнэлт, санал боловсруулсан байна. | орчин, хэрэглэгдэхүүний хүртээмж, хувьсах зардлын зарцуулалтад үнэлгээ хийж дүгнэлт, санал боловсруулсан байна. | тухай" тушаалаар НЕБ-ын 29 дүгээр сургуулийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналт, шалгалтыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Н.Нарангэрэлээр ахлуулсан ажлын хэсэгт нэгжийн дарга Г.Саранхүү, С.Сүнжидмаа нар ажиллав. Тус хяналт шалгалтын ажлын хүрээнд БНБТГ-ын шинжээч Чимэдлхамын хамт үндсэн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж, тайланг боловсруулж, ХШҮДАГ-т хүлээлгэн өгөв. Шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлын хүрээнд мэргэжлийн зөвлөмж, зөвлөгөө өгч, тухайн сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн үнэлгээ хийх, ганцаарчилсан сургалтын | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | төлөвлөгөө боловсруулах хэрэгжүүлэх талаар зөвлөгөө өгч ажиллав. Салбарын хяналтын газрын төлөвлөгөөт хяналт шалгалтын удирдамжид ялгаатай хэрэгцээтэй хүүхдэд шаардлагатай орчин, хэрэглэгдэхүүний хүртээмжийг шалгах шалгуур үзүүлэлтийг тусгасан. Түүнчлэн СХГ болон ХШҮДАГ-тай хамтран урьдчилан сэргийлэх зорилготой төлөвлөгөөт хяналт, шалгалтыг 50 ЕБС-д хийхээр төлөвлөсөн бөгөөд эхний хагас жилд 19 объектод хяналт шалгалт хийгдсэн байна. Түүнчлэн 2025 оны сүүлийн хагаст Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төслийн | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | зорилтот 18 сургууль, Боловсролын яам, Люксенбургийн ГХЯ-тай хамтран хэрэгжүүлж буй "ЕБС-ийн багш нарт тэгш хамран сургах боловсрол олгох онлайн платформ бий болгох нь" төслийн зорилтот 10 сургуульд хяналт, шинжилгээ үнэлгээний ажлыг хамтран зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна. . Хавсралт: 2 файл | | |
| 1.1.1 1 | Танхимын сургалтад хамрагдах боломжгүй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан сургалтын жишиг хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүйн сургалтыг зохион байгуулах, | - | - Арга зүйн сургалтад хамрагдсан бага боловсролын болон насан туршийн суралцахуйн багшийн тоо - Зөвлөмжийн төсөл | Явуулын багшийн сургалтын жишиг хөтөлбөр | Сургалтын жишиг хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүйн сургалтыг зохион байгуулсан байна. | Хүүхдийн ахицыг үнэлэх, зөвлөмж боловсруулж, түгээн дэлгэрүүлнэ. | Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны А/158 дугаар тушаалаар батлагдсан явуулын багшийн сургалтын жишиг хөтөлбөрүүдиийн хэрэгжилт хангалтгүй байсан тул БСҮХ-тэй хамтран монгол хэл, нийгэм ахуйн баримжаа сургалтын жишиг | 100% | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хүүхдийн ахицыг үнэлэх зөвлөмж боловсруулж, түгээн дэлгэрүүлэх ажлыг удирдлага зохицуулалтаар хангах | | | | | | хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүйн сургалтын модулийг боловсруулж, ерөнхий боловсролын сургуулийн багш, насан туршийн суралцахуйн багш нар нийт 60 албан хаагчдад сургалт зохион байгуулсан. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 176 дугаар тогтоолоор баталсан Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалыг үндэслэн сөб, бага боловсролын хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд танхимын сургалтад хамрагдах боломжгүй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан "нийгэм ахуйн баримжаа" хөтөлбөрийг боловсруулах | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ажлыг Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнтэй хамтран боловруулж, хот, хөдөөгийн 4 сургуульд туршилтаар хэрэгжүүлж, хөтөлбөрийг сайжруулж, эцэслэх ажлыг зохион багуулалтаар ханган, дэмжлэг үзүүлж хамтарч ажиллаж байна.<br>Хавсралт: 5 файл | | |
| 1.1.12 | Тува /цаатан/ хэл, соёлын жишиг хөтөлбөрийг хэрэгжүүлэх дунд шатны гарын авлага боловсруулж, хэвлүүлж, түгээж, Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын иргэд, ЕБС-ийн цаатан суралцагчид, хүүхэд, | - | - Тува /цаатан/ хэл соёлын сургалтын дунд шатны гарын авлага - Хэвлэсэн тоо | Тува /цаатан/ хэл соёлын сургалтын жишиг хөтөлбөр, анхан шат | Тува /цаатан/ хэл соёлын сургалтын дунд шатны гарын авлагын төсөл боловсруулсан байна. | Тува /цаатан/ хэл соёлын сургалтын дунд шатны гарын авлагыг боловсруулж, 300 хувь хэвлүүлж, Хөвсгөл аймгийн Цагааннуур суманд түгээсэн байна. | Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2025 оны “Чиглэл батлах тухай” А/229 дүгээр тушаалаар “Хос хэлний боловсрол, сургалт зохион байгуулахад баримтлах чиглэл” батлагдсан. Уг баримт бичигтэй холбогдуулан зарим УИХ-ын гишүүд болон холбогдох төрийн байгууллага, албан | 100% | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | залуучуудыг эх хэл, соёлдоо суралцахад дэмжих ажлыг удирдлага зохицуулалтаар хангах | | | | | | тушаалтнуудад танилцуулга хийж, хэрэгжүүлэх арга зам, чиглэлийг тодорхойлсон. Мөн уг чиглэлийн хэрэгжилтийг хангах зорилгоор Боловсролын ерөнхий газар, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, Боловсролын үнэлгээний төв, Баян-Өлгий, Ховд, Хөвсгөл аймгийн боловсролын газруудад Боловсролын яамны 2025 оны 2/2437 дугаар албан бичгээр хүргүүсэн. Бага боловсролын түвшинд тува хэлний сургалтын хөтөлбөр боловсруулагдаж, туршилтын шатанд байна. Хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд гарын авлага, дасгал ажлын дэвтрийг боловсруулан турших эхэлсэн бөгөөд казах, | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тува/цаатан иргэдийн хос хэлний ур чадварыг хөгжүүлэх, тэдний эзэмшиж буй боловсролын чанарын ялгааг бууруулахад чиглэж байна. Тува (цаатан) хүүхдэд зориулсан тува хэл, соёлын сургалтын жишиг хөтөлбөрийг хэрэгжүүлэх дунд шатны гарын авлага боловсруулах зардалд 29,125,000 сая төрөг, хэвлүүлэх зардалд 300 ш буюу 4,770,000 төгрөгийг тус тус төсөвлөж, тува хэл соёлын сургалтын дунд шатны гарын авлагыг боловсруулж байна.<br>Хавсралт: 1 файл | | |
| 1.1.13 | Сонсголын бэрхшээлтэй хүүхэд, залуучуудыг боловсролд тэгш | - төсөл, хөтөлбөрийн санхүүжилт | - Сайдын тушаал - Туслах хэрэглэгдэхүүнээр хангагдсан сонсголын | - | Сонсголын бэрхшээлтэй 50 хүүхэд, залуучуудыг тохирох хэрэглэгдэхүүн | Сонсголын бэрхшээлтэй 100 хүүхэд, залуучуудыг тохирох хэрэглэгдэхүүн | Боловсролын яамнаас Боловсролын Дэлхийн Түншлэл (GPE) байгууллагын | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хамрагдахад дэмжлэг үзүүлж, шаардлагатай туслах хэрэглэгдэхүүн ээр хангах төслийг удирдлага, зохицуулалтаар хангах | | бэрхшээлтэй хүүхдийн тоо | | ээр хангана | ээр хангана | буцалтгүй тусламжийн санхүүжилтээр “Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих” төслийн тэгш хамран сургах боловсрол бүрэлдэхүүний хүрээнд “Сонсголын бэрхшээлтэй суралцагчдад зориулсан туслах хэрэглэгдэхүүний тохируулга хийх” туршилтыг Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнтэй хамтран ирэх наймдугаар сараас хийхээр бэлтгэж байна. Дээрх үйл ажиллагаанд шаардлагатай 340 ш хромебүүкийг нийслэлийн 9 сургууль, орон нутгийн 22 сургууль болон 5 их сургуульд “Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих” төслийн санхүүжилтээр | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | худалдан авч сул сонсголтой болон сонсголын бэрхшээлтэй суралцагчдад болон тэдгээртэй ажиллаж байгаа багш нарт гардууллаа.Сонсголын бэрхшээлтэй суралцагчдад зориулсан туслах хэрэглэгдэхүүний (Chromebook) тохируулга хийгдсэнээр сонсголын бэрхшээлтэй суралцагчид тэгш хамрагдан суралцах боломжтой боллоо. Хавсралт: 2 файл | | |
| 1.1.14 | Ялгаатай хэрэгцээтэй хүүхэд, залуучуудын сурч боловсрох эрхийн хангалтын судалгаа хийх ажлыг зохион байгуулж, арга хэмжээг төлөвлөх | төсөл хөтөлбөрийн санхүүжилт | Судалгааны тайлан, зөвлөмж | - Боловсролын статистик | Судалгааны аргачлал болоюсруулагдаж, судалгааны ажлыг эхлүүлсэн байна. | Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн сурч боловсрох эрхийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хангалтын талаарх судалгааны тайлан, зөвлөмж боловсруулагдсан байна. | Боловсролын сайдын 2025 оны А/228 дугаар тушаалаар Ялгаатай хэрэгцээтэй хүүхэд, залуучуудын боловсролд хамрагдалтын нөхцөл байдлын судалгаа хийх, судалгааны үр дүнг холбогдох талуудаар | 100% | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хэлэлцүүлэх, зөвлөмж боловсруулах зардлыг баталсан бөгөөд тус тушаалын хэрэгжилтийн хүрээнд гүйцэтгэгчийн ажлын даалгавар гэрээг боловсруулж, батлуулан, судалгааны ажлыг эхлүүлээд байна. Хавсралт: 3 файл | | |
| 1.1.16 | Ялгаатай хэрэгцээтэй хүүхэд, залуучуудын өгөгдөл мэдээллийг гаргахад шаардлагатай маягт, шалгуурыг боловсруулан боловсролын статистикийн шалгуур үзүүлэлтэд тусгуулах | - | Боловсролын статистикийн шалгуур үзүүлэлт | Боловсролын статистик | Ялгаатай хэрэгцээтэй хүүхэд, залуучуудын өгөгдөл мэдээллийг гаргахад шаардлагатай маягт, шалгуурыг боловсруулсан байна. | Ялгаатай хэрэгцээтэй хүүхэд, залуучуудын өгөгдөл мэдээллийг гаргахад шаардлагатай маягт, шалгуурыг боловсруулж, боловсролын стаистик маягтад тусгуулан батлуулсан байна. | Боловсролын багц хуулийн шинэчлэлтэй холбогдуулан урт хугацааны бодлогын баримт бичиг, зорилтын хүрсэн түвшнийг тодорхойлох зорилгоор боловсролын салбарын статистикийн мэдээллийн үзүүлэлтийн хүрээг нэмэгдүүлэх, захиргааны статистикийн маягт шинэчлэн боловсруулах ажлын хүрээнд | 100% | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ялгаатай хэрэгцээтэй хүүхэд, залуучуудын өгөгдөл мэдээллийг гаргахад шаардлагатай маягт, шалгуурт санал өгч, Статистик мэдээллийн хэлтэстэй хамтран ажиллаж байна. Боловсролын яам “Боловсролын төлөөх даян дэлхийн түншлэл” (GPE) байгууллагын санхүүжилтээр “Системийн чадавхыг бэхжүүлэх” буцалтгүй тусламжийн төслийн II шатны төслийн хүрээнд Мэдээллийн систем, статистик өгөгдлийг сайжруулах ажлын хүрээнд мөн Ялгаатай хэрэгцээтэй хүүхэд, залуучуудын өгөгдөл мэдээллийг гаргахад шаардлагатай | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | маягт, шалгуурыг сайжруулан боловсруулах бөгөөд Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн А/52 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ажиллаж байна.<br>Хавсралт: 2 файл | | |
| 1.1.17 | Суралцагчийн ялгаатай хэрэгцээг тусгасан сургалтын үйл ажиллагааны шаардлага боловсруулах | - | Суралцагчийн ялгаатай хэрэгцээг тусгасан сургалтын үйл ажиллагааны шаардлага | - | -Суралцагчийн ялгаатай хэрэгцээг тусгасан сургалтын үйл ажиллагааны шаардлагын төсөл боловсруулсан байна. | Суралцагчийн ялгаатай хэрэгцээг тусгасан сургалтын үйл ажиллагааны шаардлагыг боловсруулсан байна. | Боловсролын яам “Боловсролын төлөөх даян дэлхийн түншлэл” (GPE) байгууллагын санхүүжилтээр “Системийн чадавхыг бэхжүүлэх” буцалтгүй тусламжийн төслийн II шатны төслийг Мэдээллийн систем, статистик өгөгдлийг сайжруулах, Сургалтын орчны чанарын стандартыг боловсруулах, | 70% | 70% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Хиймэл оюунд суурилсан багшийн виртуал туслахыг хөгжүүлэх, Дунд хугацааны төсвийн хүрээний дүн шинжилгээ хийх 4 чиглэлээр хэрэгжүүлж эхлээд байгаа бөгөөд Сургалтын орчны чанарын стандартыг боловсруулах хүрээнд суралцагчийн ялгаатай хэрэгцээг тсгасан сургалтын үйл ажиллагааны шаардлагыг боловсруулахаар, Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн А/52 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ажиллаж байна. Төслийн хүрээнд гүйцэтгэгчийн ажлын даалгаварт Суралцагчийн ялгаатай хэрэгцээг тусгасан сургалтын үйл ажиллагааны шаардлага боловсруулахтай | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | холбоотой саналыг боловсруулж тусгасан. Хавсралт: 1 файл | | |
| 1.1.18 | Сургуулийн өмнөх боловсрол, бага боловсролын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн тохируулга хийх арга зүйн удирдамжийг БСҮХ-тэй хамтран боловсруулах | - | Удирдамж | - | Сургуулийн өмнөх боловсрол, бага боловсролын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн тохируулга хийх арга зүйн удирдамжийн төсөл боловсруулсан байна. | Сургуулийн өмнөх боловсрол, бага боловсролын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн тохируулга хийх арга зүйн удирдамж батлагдсан байна. | Сургуулийн өмнөх болон бага боловсролын сургалтын хөтөлбөрийн шинэчлэлтэй уялдуулан хөтөлбөрт тохируулга хийх арга зүйн удирдамжийн төслийг Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнтэй хамтран боловсруулаад байна. | 100% | 90% |
| 1.1.19 | Тэгш хамран сургах боловсролын талаар баримтлах чиглэлийг БНБТГ-тай хамтран шинэчлэн боловсруулж, батлуулах | - | Сайдын тушаал | БШУ-ны сайдын 2022 оны А/553 дугаар тушаал | Тэгш хамран сургах боловсролын талаар баримтлах чиглэлийн төслийг боловсруулсан байна. | Тэгш хамран сургах боловсролын талаар баримтлах чиглэл батлагдсан байна. | Боловсролын сайдын 2025 оны А/228 дугаар тушаалаар "Ялгаатай хэрэгцээтэй хүүхэд, залуучуудын хамрагдалтын нөхцөл байдлын судалгаа хийх, бодлогын зөвлөмж, баримт бичиг боловсруулах зардлыг | 70% | 70% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | батлуулсан бөгөөд: 1. Ялгаатай хэрэгцээтэй хүүхэд, залуучуудын боловсролд хамрагдалтын нөхцөл байдлын судалгаа хийж, зөвлөмж боловсруулна. 2. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн сурах эрхийн нөхцөл байдлын судалгаа хийж, зөвлөмж боловсруулна 3. Дээрх судалгаа, зөвлөмжид үндэслэн тэгш хамран сургах боловсролын талаар баримтлах чиглэлийн төсөл боловсруулах гүйцэтгэгчийг сонсгон шалгаруулж судалгааны ажлыг эхлүүлээд байна. судалгааны зөвлөмжид үндэслэн Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны А/553 дугаар тушаалар | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | батлагдсан тэгш хамран сургах боловсролын талаар баримтлах чиглэлийг шинэчлэн боловсруулж батлуулах ажлыг зохион байгуулна.<br>Хавсралт: 3 файл | | |
| 1.1.20 | Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн /эрх нь хязгаарлагдсан хүүхэд, хүчирхийлэлд дарамтад өртсөн, асрамж халамжийн төвд амьдарч буй/ сурч боловсрох эрхийг хангаж, сургалтын орчин, сурах бичиг хэрэглэгдэхүүнээр хангах, мэргэжлийн болон дээд боловсрол эзэмших тэгш боломжийг нэмэгдүүлэх ажлыг уридлага | -улсын төсөв | - сурах бичиг, сургалтын хэрэгдэгдэхүүний тоо - нөлөөллийн ажлын тоо | - ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн сурч боловсрох эрхийн хэрэгжилтийн тандан судалгааны тайлан, зөвлөмж | - Эрх хязгаарлагдсан хүүхдийг сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангасан байна. - Ялгаатай хэрэгцээтэй хүүхдэд сурч боловсрох эрхээ эдлэх талаар нөлөөллийн ажил зохион байгуулсан байна. | - Цахим сургалтад хамрагдах орчин нөхцөлийг бүрдүүлсэн байна. - Ялгаатай хэрэгцээтэй хүүхдэд сурч боловсрох эрхээ эдлэх талаар нөлөөллийн ажил 3 зохион байгуулагдсан байна. | Ялгаатай хэрэгцээтэй суралцагчдын сурч боловсрох эрхийг хангаж, сураглтын орчин, сурах бичиг хэрэглэгдэхүүнээр хангах хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүллээ. Үүнд: 1. Боловсролын сайд П.Наранбаярын хамт 2025 оны 1 дүгээр ШШГЕГ-ын харъяа сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад ажилласан. Мөн УИХ дахь ХЭ-ийн дэд хороо, ХЭҮК-той хамтран мөн тус байгууллагад ажилласан. ШШГЕГ-ын харьяа Сургалт | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | зохион байгуулалтаар хангах | | | | | | хүмүүжлийн тусгай байгууллагад хүмүүжиж, НЕБ-ын 110-р сургуульд суралцаж буй хүүхдүүдийн сурах эрхийг хангаж, 10 багц 860ш сурах бичиг, 5 нөүтбүүк, 15 хроум бүүкээр хангаж, хүмүүжиж буй 41 суралцагчийг мэдлэ цахим сургуульд хамруулж, эрх нь хязгаарлагдсан хүүхдүүдийг боловсролын үйлчилгээнд бүрэн хамруулав. Сургалтын хэрэглэгдэхүүнээр бүрэн хангаж, мэдлэ цахим сургуульд хамруулсны үр дүнд хоригдож буй хүүхдүүдээс 1 нь улсын түүхийн олимпиадаас хүрэл медаль, 1 нь химийн олимпиадаас мөн хүрэл медаль хүртэж их дээд сургуульд элсэн суралцах боломж нээгдэж байна. Мөн | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 3 хүүхэд МСҮТ-д суралцаж байна. Мөн тус сургуульд суралцаж буй эрх нь хязгаарлагдсан хүүхдүүдийг цахим сургалтад хамруулах зорилгоор 2 ш ухаалаг самбар хүлээлгэн өгөхөөр худалдан авах ажиллагааны тендер зарлагдсан. 2. Асрамж халамжийн төвд амьдарч буй хүүхдүүдийн сурах эрхийг хангах талаар халамжийн төвийн удирдлагууд, багш, нийгмийн ажилтнуудад арга зүйн сургалт зохион байгуулж, сургууль завсардсан хөгжлийн бэрхшээлтэй 8 суралцагчийг дэмжих үйлчилгээнд хамруулах ажлыг арга зүй, зохицуулалтаар хангав. Мөн Нийгмийн халамжийн тухай | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хуулийн 22 дугаар зүйлд заасанчлан хүнд нөхцөлд амьдарч буй хүүхдийг боловсрол эзэмшихэд дэмжлэг үзүүлэх хүрээнд асрамж халамжийн төвд амьдарч буй хүүхдийг сургатын цахим хэрэгдэгдэхүүнээр хангах асуудлаар ГБХНХЯ-ны Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэстэй ярилцаж, 2025 оны 8 дугаар сард энэхүү ажлыг зохион байгуулахаар тогтлоо. Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг сурч боловсрох эрхээ эдлэх талаар Кристина нобелийн хүүхдийн сантай хамтран нөлөөллийн 1 ажил зохион байгуулсан.<br>Хавсралт: 4 файл | | |
| 1.1.9. | Хот, хөдөөгийн болон нийгэм, | - | - | - | - | | - | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | эдийн засгийн хувьд ялгаатай бүлгийн хүүхэд, залуучуудын боловсролын чанарын ялгааг арилгаж, малчин эцэг, эх, асран хамгаалагчийн дэргэд бага боловсрол эзэмших боломжийг бүрдүүлнэ. | | | | | | | | |
| 1.1.9.1 | Алслагдсан бүс нутаг, хил орчмын суурьшлын бүст ажиллаж буй албан хаагчдын болон малчдын хүүхдүүдийн хамрагдалтыг нэмэгдүүлэх арга хэмжээг удирдлага, зохицуулалтаар хангах | -улсын төсөв | -Боловсролын үйлчилгээг цахимаар авсан хөдөө, орон нутгийн болон нийгэм, эдийн засгийн хувьд ялгаатай бүлгийн хүүхэд, залуучуудын тоо | -15265 | - | -17700 | Боловсролын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны А/109, А/92 дугаар тушаалаар байгуулагдсан Боловсролын чөлөөт бүс арга хэмжээний хүрээнд хилчид болон хил орчмын алслагдсан бүс нутгийн малчин иргэдийн хүүхэд гэрт ойр бага боловсрол эзэмших боломж бүрдүүлэх зорилгоор багийн бага сургууль байгуулах үйл ажиллагааг удирдлага, зохион | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байгуулалтаар хангах чиг үүрэг бүхий хамтарсан ажлын хэсгийн хурлыг 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдөр зохион байгууллаа. Ажлын хэсгийн хурлаар 2025-2026 онд Увс аймгийн Давст сумын Боршоо баг, Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сумын Хөндий баг, Төв аймгийн Батсүмбэр сумын Үдлэг баг гэсэн 3 байршилд багийн бага сургууль, цэцэрлэгийн барилга барих, Ховд аймгийн Үенч сумын ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны засварт тус тус санхүүжилт хийх саналыг танилцууллаа.<br>Хавсралт: 3 файл | | |
| 1.1.9.2 | Сүм хийдэд шавилан сууж буй хүүхэд, залуучуудыг боловсролд тэгш хамруулах | 193,500 | Буддын сүм хийдэд шавилан сууж буй хүүхдүүдийн боловсролын | Боловсролын сайдын 2024 оны А/164 дүгээр тушаал | -сүм хийдэд, шавилан сууж буй хүүхэд, тэдний эцэг эх, дацан хийдийн удирдлагад | - буддын сүм хийдэд шавилан сууж буй хүүхдүүд боловсролын үйлчилгээнд | ЗГ-ын 2024 оны 48 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд Боловсролын сайдын 2024 оны | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ажлыг удирдлага, зохицуулалтаар хanган ажиллах | | үйлчилгээнд хамрагдалтын хувь | | чиглэсэн нөлөөллийн ажил зохион байгуулсан байна. | 100 хувь хамрагдсан байна. | А/145, 2025 оны А/76 дугаар тушаалыг тус тус батлуулж, нийслэлийн ЕБ-ын 112 р сургуулийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг шинэчилж, тусгай зөвшөөрлийг еб, боловсрол нөхөн олгох хөтөлбөр, цахим сургалт зохион байгуулах чиг үүрэгтэй болгон өөрчилж, монгол улсад дацан хийдэд шавилан сууж буй хүүхдүүд болон БНЭУ-д дацан хийдэд шавилан сууж буй 302 ламыг боловсрол нөхөн олгох сургалтад хамруулж, ингэснээр монгол лам хүүхдүүдийг боловсролд бүрэн хамрууллаа. БНЭУ-д шавилан сууж буй монгол лам хүүхдүүдийн бүртгэл судалгаанд нийт 433 лам сурагчийн бүртгэл, судалгааг нэгтгэн боловсруулсан. | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Судалгааны үр дүнд үндэслэн 302 сурагчийг боловсрол нөхөн олгох хөтөлбөрт, 431 сурагчийг монгол хэл, бичиг, соёлын сургалтад хамруулж байна. Мөн Энэтхэг улсад шавилан сууж буй хүүхдүүдийн эцэг эхэд зориулсан захидлыг дамжуулан хүргэж, бодит мэдээлэл болон хэрэгцээт зөвлөгөө өгч ажиллав. Боловсролын сайдын 2025 оны А/97 тушаалаар ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг боловсрол эзэмшихэд шаардлагатай зардал болох 134,8 сая төгрөгийг баталж, 112р сургуульд танхимаар болон цахимаар суралцаж буй лам хүүхдүүдийг боловсролд тэгш хамруулахад шаардлагатай | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сугалт үйл ажиллагаанд зарцуулж байна. Мөн энэ тушаалын хэрэгжилтийн хүрээнд сүм хийдэд шавилан сууж буй хүүхдүүдийг боловсролд хамруулах асуудлаар сүм хийдийн удирдлагуу, лам хүүхдүүд тэдний эцэг эхэд нөлөөллийн ажил зохион байгуулсан ба үүний үр дүнд лам хүхдүүд сургуульд хамрагдахдаа дуртай болж, таслахгүй хамрагдаж байгааг 112р сургуулиас мэдээллэв. Мөн лам хүүхдүүдийн цахим сургалтад зориулж 40 ш хроум бүүкийг олгоод байна. Цаашид 112р сургуульд цахим танхим 2-ыг байгуулахаар худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна. | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Хавсралт: 8 файл | | |
| Гурав. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ | | | | | | | | | |
| 3.1. | Багшлах хүний нөөцийг чадавхжуулж, цэцэрлэгийн 10000 багш, бага ангийн 2000 багш, ерөнхий боловсролын сургуулийн 11000 багш, англи хэлний 2000 багш, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын 2000 багшийг гадаад, дотоодод бэлтгэнэ. | - | - | - | - | | - | 100% | 90% |
| 3.1.1 | Тусгай хэрэгцээт боловсролын багшийг бэлтгэх, СӨБ болон ЕБС-ийн багш нарыг тэгш хамран сургах боловсролын чиглэлээр | 285.0 | - Тусгай хэрэгцээт боловсролын үндсэн болон хөрвөх ангийн төгсөгч, элсэгчийн тоо - Мэргэшүүлэх сургалтад хамрагдсан багшийн хувь | - | -ТХБ-ын бакалавр болон хөрвөх ангийг 35 хүн төгссөн байна. - Арга зүйн болон мэргэшүүлэх сургалтад 500 багшийг хамруулсан байна. | -ТХБ-ын бакалавр болон хөрвөх ангид 50 хүн элсэн суралцсан байна. -Арга зүйн болон мэргэшүүлэх сургалтад 1500 багшийг | Боловсролын сайдын 2024 оны А/118 дугаар тушаалаар батлагдсан удирдамжаар “Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих” (EQUAL) төслийн "Тэгш | 100% | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | мэргэшүүлэх, чадавхжуулах сургалтад хамруулах ажлыг удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллах | | | | | хамруулсан байна. | хамран сургах боловсрол" бүрэлдэхүүний хүрээнд МУБИС-ийн Боловсрол судлалын сургуультай хамтран “Багш, тусгай хэрэгцээт боловсрол” мэргэжлээр хөрвөх сургалт зохион байгуулах хөтөлбөрийг бий болгож, багш мэргэжлээр төгссөн хүмүүст зориулсан "Багш, тусгай хэрэгцээт боловсрол"-хөтөлбөрийн хөтвөх ангийн нээсэн. 2024-2025 оны хичээлийн жилд туслийн санхүүжилтээр зорилтот 18 сургуулийн 18 багш, нийт 25 хүн багш, тусгай хэгрэгцээт боловсрол мэргэжлээр хөрвөх анги төгсөж байна. Мөн багш, тусгай хэрэгцээт боловсролын үндсэн хөтөлбөрийг 6 | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | суралцагч төгсөж байна. МУБИС-ийн Тусгай хэрэгцээт боловсролын тэнхимтэй хамтран 90 багшид мэргэшүүлэх сургалт зохион байгуулсан. “Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих” (EQUAL) төслийн хүрээнд ерөнхий боловсролын 18 сургуулийн 540 багшид ажлын байран дээр нь арга зүйн сургалтыг зохион байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчтай ажиллах, ГСТ боловсруулах, хүүхдийн ахицыг нэлэх чиглэлээр мэргэшүүлж, тусгай хэрэгцээт боловсролын мэргэжлийн бүлгийг байгуулан ажиллуулах ажлыг удирдлага зохион байгуулатаар ханган ажиллалаа. Хавсралт: 3 файл | | |

| Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1. | Урт болон богино хугацааны бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөр, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн болон үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналт, архив, албан хэрэг хөтлөлт, дотоод үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах, байгууллагын соёлыг төлөвшүүлнэ. | - | - | - | - | | - | 100% | 100 % |
| 4.1.1 | Хууль тогтоомж, шийдвэрийн болон үйл ажиллагааны төлөвлөлтийг хийх, хэрэгжилтийг гүйцэтгэх, тайлагнах, | - | Төлөвлөгөө, тайлан, архив, албан хэрэг хөтлөлт | 2024 оны гүйцэтгэлийн түвшингээр | 1.Хууль тогтоомж, шийдвэрийн болон үйл ажиллагааг тогтоосон хугацаанд хэрэгжүүлэн тайлагнасан байна. 2.Архив, | 1.Хууль тогтоомж, шийдвэрийн болон үйл ажиллагааг тогтоосон хугацаанд хэрэгжүүлэн тайлагнасан байна. 2.Архив, | Хариуцсан чиг үүргийн хүрээнд өдөр тутмын үйл ажиллагаандаа хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн болон үйл ажиллагааны төлөвлөлтийг хийж, хэрэгжилтийг арга | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | архив, албан хэрэг хөтлөлт, дотоод үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах | | | | албан хэрэг хөтлөлт, дотоод үйл ажиллагааны тасралтгүй байдлыг зохих журмын дагуу хангасан байна. | албан хэрэг хөтлөлт, дотоод үйл ажиллагааны тасралтгүй байдлыг зохих журмын дагуу хангасан байна. | зүйн удирдлага, зохион байгуулалтаар ханган, ажиллаж, нэгжийн үйл ажиллагааг дээд шатны удирдлагад тайлагнаж, архив, албан хэрэг хөтлөлт, дотоод үйл ажиллагааны тасралтгүй байдлыг ханган ажилласан. | | |
| 4.2. | Төрийн албан хаагчийн нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлж ажиллах | - | Гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан мэдээ, мэдээлэл, судалгаа | - | Хугацаанд нь чанартай боловсруулж, тайлагнасан байна. | | - | 100% | 100 % |
| 4.2.1 | ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, | - | Гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан мэдээ, мэдээлэл, судалгаа | - | Хугацаанд нь чанартай боловсруулж, тайлагнасан байна. | Хугацаанд нь чанартай боловсруулж, тайлагнасан байна. | Холбогдох хууль тогтоомж, МУЗГ-ын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын зорилт, хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд яамны гүцэтгэлийн төлөвлөгөөнд үндэслэн нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг хугацаанд нь боловсруулж, | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх | | | | | | хэрэгжилтийг ханган ажиллав. - Бодлогын баримт бичиг боловсруулж, ялгаатай хэрэгцээтэй суралцагчийн талаар холбогдох судалгаа, мэдээллийг гаргаж, яамны удирдлагууд, холбогдох нэгжийн албан тушаалтанд хүргүүлж, хамтран ажиллав. | | |
| 4.2.2 | Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллаж ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд мэдүүлэх | - | ХАСХОМ | - | ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд мэдүүлсэн байна. | Төрийн албаны тухай хууль, Авилгын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон | ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд мэдүүлж, авилга ашиг сонирхлын зөрчлөөс ангид, ёс зүйн зөрчилгүй ажиллаж байна. | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бусад хуулийг чанд мөрдөж, авилга, ашиг сонирхлын болон ёс зүйн зөрчилгүй ажилласан байна. | | | |

*Үнэлсэн:* .........................

*..........................................* *.........................* */................................/*

*(албан тушаал )* *(гарын үсэг)*

*.........................*

*(огноо)*

*Тайлагнасан:* .........................

*..........................................* *.........................* */................................/*

*(албан тушаал )* *(гарын үсэг)*

*.........................*

*(огноо)*